



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/453

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын
51 дүгээр сургуулийн эргэлтийн бус
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 83,971,882 (наян гурван сая есөн зуун далан нэгэн мянга найман зуун наян хоёр) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн Ерөнхий боловсролын 51 дугаар сургууль (Ю.Энхтуул)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 5 нэр төрлийн 2,478,400 (хоёр сая дөрвөн зуун далан найман мянга дөрвөн зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгаж, 14 нэр төрлийн 81,493,482 (наян нэгэн сая дөрвөн зуун ерэн гурван мянга дөрвөн зуун наян хоёр) төгрөгийн хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 768,000 (долоон зуун жаран найман мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 230,400 (хоёр зуун гучин мянга дөрвөн зуу) төгрөгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Нийслэлийн Ерөнхий боловсролын 51 дүгээр сургууль (Ю.Энхтуул)-д, орлого төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс (М.Мандах)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115059001235



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 31 дүгээр сарын 29-ны өдрийн А/455 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Ерөнхий боловсролын 51 дүгээр сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр
1	Зургийн аппарат /lumix/	12	ш	1	178,020	178,020	178,020	0	эвдэрхий	актлах	3,000
2	Оёдолын машин	11	ш	1	430,000	430,000	430,000	0	эвдэрхий	актлах	10,000
3	Принтер /hp/	11	ш	1	1,440,805	1,440,805	1,440,805	0	эвдэрхий	актлах	10,000
4	Цаас цологч	9	ш	1	80,000	80,000	80,000	0	эвдэрхий	актлах	устгах
5	Компьютер /Pioneer/	9	ш	1	704,000	704,000	704,000	0	эвдэрхий	актлах	10,000
6	Зөөврийн компьютер /Dell/	8	ш	1	949,000	949,000	949,000	0	эвдэрхий	актлах	10,000
7	Проектор /Aser/	8	ш	1	769,000	769,000	769,000	0	эвдэрхий	актлах	устгах
8	Принтер /Samsung/	8	ш	1	434,500	434,500	434,500	0	эвдэрхий	актлах	4,000
9	Кодоскоп	8	ш	1	170,000	170,000	170,000	0	эвдэрхий	актлах	устгах
10	Нетбүүк /Lenovo/	6	ш	62	1,136,472	70,461,264	70,461,264	0	эвдэрхий	актлах	620,000
11	Хоёрдугаар хоолны тогоо /170л/	11	ш	1	2,750,000	2,750,000	2,750,000	0	эвдэрхий	актлах	30,000
12	Пийшин /4 ширэмтэй/	11	ш	1	1,900,000	1,900,000	1,900,000	0	эвдэрхий	актлах	30,000
13	Зөөврийн компьютер /HP/	5	ш	1	1,400,000	1,400,000	1,400,000	0	эвдэрхий	актлах	10,000
Машин тоног төхөөрөмжийн дүн						81,666,589					737,000
1	Сандал /уншигчийн/	13	ш	2	29,700	59,400	59,400	0	эвдэрхий	актлах	устгах
2	Ширээ сандал /2 суудалтай/	13	ш	1	56,300	56,300	56,300	0	эвдэрхий	актлах	2,000
3	Жин хэмжигч	13	ш	1	1,400,000	1,400,000	1,400,000	0	эвдэрхий	актлах	устгах
4	Ширээ сандал /сурагч/	12	ш	6	52,000	312,000	312,000	0	эвдэрхий	актлах	6,000
5	Ширээ /компьютерийн/	11	ш	1	57,593	57,593	57,593	0	эвдэрхий	актлах	3,000
6	Гурван дамжлагатай угаалтуур	11	ш	1	420,000	420,000	420,000	0	эвдэрхий	актлах	20,000
Тавилга эд хогшлийн дүн						2,305,293					31,000
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн						83,971,882					
Үүнээс: Худалдан борлуулах хөрөнгийн дүн						14					768,000
Устгах хөрөнгө						5					
НӨАУГ-т төвлөрүүлэх 30%						230,400					230,400